

# ТА ЧЕХ УЛСАД ХУУЛЬ БУСААР АМЬДАРЧ БАЙНА УУ? ГЭРТЭЭ ХАРИХ МӨНГӨГҮЙ БАЙНА УУ?

Хууль бусаар амьдарч байгаа гадаадын иргэдийг сайн дураар орон нутагтаа буцах төсөлд  
**хамааруулах хэлбэрээр Чех улс таньд туслах санал гаргаж байна.**

Төсөл таньд ямар боломж олгох вэ?

- **Эх нутаг руу тань хүргэх** онгоцны билет авч өгөх ба замд явахад шаардлагатай мэдээлэл өгч тусална

Та төсөлд бүртгүүлбэл таны өмнө нь хууль бусаар оршин сууж байсан явдлыг ямар нэгэн хэлбэрээр авч шийдвэрлэх үү?

- Та Чех улсад оршин суух зөвшөөрөлгүйгээр амьдарч чех улсын хуулийг зөрчсөн тул үүнийг зохих албан байгууллага заавал хуулийн дагуу авч шийдэх ёстой. Харин та өөрөө ирж энэ төсөлд бүртгүүлвэл таньд чехийн нутагт орж ирэхийг хориглосон хугацааны хэмжээг тодорхой мэдэх боломж олдоно. Энэ тохиолдолд та „А“ бүлэгт хамрагдана. (Доорхи хүснэгтийг хар)
- Хэрэв та төсөлд бүртгүүлээд мөн буцаж явахтай холбоотой зардлыг өөрөө төлбөл таньд чех оронд орж ирэхийг хориглосон хугацааны хэмжээ багасна. Энэ тохиолдолд та „Б“ бүлэгт хамрагдана.

Чех улсын нутаг дэвсгэрт өмнө нь хууль бусаар оршин суусан хугацааны хэмжээ	Чех улсын нутаг дэвсгэрт орж ирэхийг хориглосон хугацаа	
	А бүлэг	В бүлэг
6 сар хүртэл (½ жил хүртэл)	3 сар (1/4 жил)	1 сар
12 сар хүртэл (1 жил хүртэл)	6 сар (1/2 жил)	2 сар
18 сар хүртэл (1 ба ½ жил хүртэл)	9 сар (3/4 жил)	3 сар
24 сар хүртэл (2 жил хүртэл)	12 сар (1 жил)	4 сар
30 сар хүртэл (2 ба ½ жил хүртэл)	15 сар (1 ба ¼ жил)	5 сар
36 сар хүртэл (3 жил хүртэл)	18 сар (1 ба ½ жил)	6 сар
42 сар хүртэл (3 ба ½ жил хүртэл)	21 сар (1 ба ¾ жил)	8 сар
48 сар хүртэл (4 жил хүртэл)	24 сар (2 жил)	12 сар
54 сар хүртэл (4 ба ½ жил хүртэл)	27 сар (2 ба ¼ жил)	16 сар
60 сар хүртэл (5 жил хүртэл)	30 сар (2 ба ½ жил)	20 сар
60-аас дээш сар (5 жил ба түүнээс дээш)	36 сар (3 жил)	24 сар

Төсөлд хамрагдахын тулд та юуг хангасан байх ёстой вэ?

- Хүчинтэй гадаад паспорттай байна.
- Санаатай үйлдсэн эрүүгийн хэргээр Чех улсын нутаг дэвсгэрт ял авч шийтгэгдээгүй болон эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөгдөөгүй байна.
- Таныг нутаг дэвсгэрээс албадан гаргах тухай (оршин суухыг хориглох) захиргааны үйл ажиллагаа эхлээгүй байна.
- Хуулийн дагуу төлөх ёстой захиргааны үйл ажиллагааны хураамж болох 1000 крон нь төлөх цорын ганц зардал болно. **Таны төсөлд бүртгүүлэхтэй холбоотой бусад бүх ажиллагаа төлбөргүй болно**
- Хэрэв өөрийн зардлаар нутаг явах(онгоцоор бол хамаарахгүй) бол дамжин өнгөрөх орнуудаар нэвтрэх хүчинтэй транзит визээ үзүүлэх ёстой.

Төсөлд бүртгүүлэх талаар хаана хандаж болох вэ? Ямар хэлээр?

- Бүх Гадаад иргэдийн харъяа цагдаагийн газарт.
- Утсаар холбогдох юмуу биеэр ирж уулзахдаа чех хэлээр ойлгож ярьдаг хүнтэй ирээрэй.
- **Та өөрийн биеэр оролцох нь чухал!**
- Тус санал **2009 оны 9-р сарын 15-аас 12-р сарын 15-ыг хүртэл** үйлчилнэ. Хүсэлт гаргагчдын тоог хязгаарлаагүй.
- Хүсэлт гаргагч бүр **зөвхөн нэг удаа** л бүртгүүлж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг авч болно:

- **Дотоод яам** ([www.mvcr.cz](http://www.mvcr.cz)), утас.: **974 832 421** (даваа – баасан 9-ээс 15 цаг хүртэл)
- **Олон улсын шилжин суурьших бодлогын байгууллага** ([www.iom.cz](http://www.iom.cz)), утас.: **233 370 160**, E-мэйл: [vintr@iom.cz](mailto:vintr@iom.cz), [karban@iom.cz](mailto:karban@iom.cz); [Dukelských hrdinů 35, Praha 7](mailto:Dukelských_hrdinu_35_Praha_7) (даваа – баасан 9-ээс 15 цаг хүртэл))

Цагдаагийн газарт ирж уулзахад тусламж хүсэж доорхи төрийн бус байгууллагуудын аль нэгэнд хандаж болно:

- Арцидиезийн буяны байгууллага Прага, Пернерова 20, Прага 8, утас: 224 813 418, 737 282 803 (*Arcidiecézní charita Praha, Pernerova 20, Praha 8*)
- Цагаачдад туслах байгууллага, Ковааржскаа 4, Прага 9, утас: 284 683 545, 739 413 983 (*Organizace pro pomoc uprchlíkům, Kovářská 4, Praha 9*)
- Цагаачдад туслах байгууллага, Жишковаа 1, Чешское Будейовице, утас 739 413 983 (*Organizace pro pomoc uprchlíkům, Žižkova 1, České Budějovice*)
- Төвлөрөлтөнд нэгдэхэд зөвлөлгөө өгөх газар, Сеноваажнаа 2, Прага 1, утас: 224 216 758, 603 281 269 (*Poradna pro integraci, Senovážná 2, Praha 1*)
- Төвлөрөлтөнд нэгдэхэд зөвлөлгөө өгөх газар, Хороваа 6, Уустий над Лабем, утас: 475 216 536, 603 856 375 (*Poradna pro integraci, Horova 6, Ústí nad Labem*)
- Төвлөрөлт ба шилжин суурьшихад зориулсан нэгдэл, Сеноваажнаа 2, Прага 1, утас: 224 224 379 (*Sdružení pro integraci a migraci, Senovážná 2, Praha 1*)
- Цагаачдын асуудлаар ажилладаг иргэдийн нэгдэл, (СОЗЭ), tel: 545 213 643, 602 586 092 (*Sdružení občanů zabývajících se emigranty (SOZE), Mostecká 5, Brno*)
- Диецезийн буяны байгууллага Плезнь, Цукроварскаа 16, Плезнь, 377 441 736, 731 433 096, 731 433 008 (*Diecézní charita Plzeň, Cukrovarská 16, Plzeň*)
- Хүний эрхийн гүүр, 17р листопаду 216, Пардубице, утас: 467 771 170 (*Most pro lidská práva, 17. listopadu 216, Pardubice*)
- Диецезийн буяны байгууллага (*Diecézní charita Hradec Králové, Velké nám. 37. H. Králové*) tel: 495 063 135